



ВИДЕО КОНТЕНТ, ПОДКАСТ
БҮТЭЭГЧ КОМПАНИУДАД

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВ

Нам Ян Жугийн гудамж 32/1,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13335
Утас: 45 39 94, Факс: (976-11) 45 86 99,
Цахим шуудан: info@nccd.gov.mn,
Цахим хуудас: www.nccd.gov.mn

2026.08.26 № 3-3/1173.

танай _____-ны № _____-т

Үнийн санал авах тухай

Манай төвөөс БЗДХ, ХДХВ, ДОХ-ын талаар нийт хүн ам, эрсдэлт бүлгийн хүн амд шинжлэх ухааны нотолгоонд суурилсан эрүүл мэндийн мэдээ мэдээлэл хүргэх үйл ажиллагааны хүрээнд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт танин мэдэхүйн подкаст нэвтрүүлэгт оролцож, видео контент бүтээлгэхээр төлөвлөж байна. Эрүүл мэндийн боловсрол, нийгмийн эерэг хандлагыг дэмжсэн подкаст, видео контент бэлтгэн хүргэж байсан туршлагатай контент бүтээгч байгууллагуудыг хамтран ажиллахыг урьж байна. Энэхүү үйл ажиллагааг 12,750,000 (арван хоёр сая долоон зуун тавин мянга) төгрөгийн төсөвт өртгөөр хийлгэх тул подкаст/ видео контент бүтээгч компаниуд үнийн саналаа "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дах заалтын дагуу 2026 оны 09 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Саналыг байгууллагын албан тоотоор баталгаажуулж холбогдох материалын бүрдэл (улсын бүртгэлийн гэрчилгээ, ижил төстэй ажлын гэрээ, мэдээлэл)-ийг ханган tender@nccd.gov.mn хаягаар ирүүлнэ үү.

ЗАХИРАЛ



С.ЭНХБОЛД

ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын ТСА-ны 2026 оны I, II улиралд төлөвлөсөн
 үйл ажиллагааны хүрээнд БЗДХ, ХДХВ, ДОХ-ын талаар
 эрүүл мэндийн боловсрол олгох видео контент,
 подкаст бүтээх ажлын даалгавар

№	Үйл ажиллагаа	Тоо хэмжээ	Тавигдах шаардлага
1	Нийт хүн ам болон эрсдэлт бүлгийн хүмүүст БЗДХ, ХДХВ, ДОХ-ын талаар эрүүл мэндийн боловсрол олгох видео контент	- 4 төрлийн богино видео контент - 55-60 секунд үргэлжлэх	- Видео контент нь агуулга найруулгын алдаагүй, энгийн ойлгомжтой байх - Дуу, дүрсний өндөр чанартай (full HD/4K) тайлбар бичвэр (subtitle), анимейшн зэрэг мультимедиа элементийг багтаасан байх - Олон нийтийн цахим сүлжээн (TikTok, Facebook Reels, Instagram Reels, YouTube Shorts)-д ашиглах боломжтой байх
2	Нийт хүн ам болон эрсдэлт бүлгийн хүмүүст БЗДХ, ХДХВ, ДОХ-ын талаар нотолгоонд суурилсан мэдээ мэдээлэл хүргэх подкаст ярилцлага	- 1 дугаар (зочинтой ярилцлага) - 60-90 минут үргэлжлэх	- Подкаст нэвтрүүлэг нь олон төрлийн цахим сувгаар хүрдэг. - Эрүүл мэндийн нарийн төвөгтэй сэдвүүдийг шинжлэх ухааны үндэслэлтэй, судалгаатай, энгийн ойлгомжтой хэлбэрээр олон нийтэд таниулах чадвартай байх. - Подкаст нь эрүүл мэндийн мэдээлэл, зөвлөгөөг хүртээмжтэй хүргэх замаар нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, улмаар нийгэмд үзүүлэх эерэг нөлөө, хүртээмж өндөртэй байна - Хөтлөгч болон уран бүтээлчид нь нийгэмд эерэг дүр төрхөөр танигдсан, ёс зүйг эрхэмлэгч
3	Бүрдүүлэх материал	- Үнийн санал - Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар - Ижил төстэй ажил (видео контент, медиа бүтээл, нэвтрүүлэг) гүйцэтгэж байсан ажлын гэрээ, бүтээлийн жишээ холбоос (2-оос доошгүй)	